

ХӨШӨӨ ЦАЙДАМ ДАХЬ ТҮРЭГИЙН ХААНТ УЛСЫН ҮЕИЙН ДУРСГАЛЫН АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ


Монгол оронд археологийн судалгаа хийсэн анхны газрын нэг болох Орхоны хөндийн Хөшөө Цайдамд буй Дорнод Түрэг улсын хаад язгууртанд зориулан босгосон тахилын онгонууд нь дэлхийн Түрэг судлал, Төв Азийн археологийн судалгаанд онцгой байр суурийн эзэлдэг шинжлэх ухааны асар их үнэ цэнтэй дурсгал юм.

Энэхүү бунхант булшийг 1889 онд Оросын эрдэмтэн Н.М.Ядринцев анх илрүүлэн Түрэгийн язгууртны бичигт хөшөөний талаарх мэдээллийг дэлхий дахинд мэдээлсэн байна. Үүний дараа 1890 онд Финляндын эрдэмтэн Г.Гейкелээр удирдуулсан шинжилгээний анги ирж бичигт хөшөөнүүдийг голлон судалсан байна.

1891 онд Оросын ШУ-ны академич В.В.Радловоор удирдуулсан “**Орхон шинжилгээний анги**”-ийг хүрэлцэн ирж Түрэгийн хаадын булшны дотоод зохион байгуулалтын судлах зорилгоор Культегин болон Билгэ хааны онгонд 8,65 м урт 2,26 м өргөн, 1 м гүн малталт хийжээ. Хожим 1912 онд В.Л.Котвич тэргүүтэй эрдэмтэд Культегиний онгоноос хойш хамгийн захад орших дурсгалыг малтлага хийж үзэхэд 1,5 метрийн гүнд нүүрс бүхий нүх байсныг илрүүлэн олсон байна.

1933-1934 онд Оросын эрдэмтэн Д.Д.Букинич Хөшөө Цайдамд ажиллан хойд талын жижиг онгонуудыг нийлээд судалжээ. Тухайлбал шувууны зурагтай хавтан бүхий хашлагыг 5 м гүн ухаж түүний ойролцоо хөндөгдөөгүй нэгэн хашлагыг 3,5 м гүн малтсан нь ямар нэгэн биет олдвор илрүүлж олоогүй ч өмнө нь В.В.Радлов Билгэ хаан ба Культегиний дурсгалыг тахилын сүм хэмээн зөв олж тогтоосон боловч хойд талын хоёр жижиг дурсгалыг тэдний булш гэж үзэж байсан буруу дүгнэлтийг малтлага судалгааны үр дүнгээр залруулж чадсан байна.

1958 онд Монгол-Чехословакийн хамтарсан экспедици Оросын эрдэмтэн археологич Л.Ийсл, Монголын эрдэмтэн Н.Сэр-Оджав нарын удирдлагаар Культегиний тахилын онгоныг өргөн хэмжээгээр малтан судлах ажлыг гүйцэтгэсэн байна. Энэхүү малтлага судалгаагаар Түрэгийн хаад язгууртны та



хилын том онгоны бүтэц, зохион байгуулалтын онцлогийг сэргээн тодруулахад ач холбогдолтой судалгаа болжээ.

1980-аад оны үед Монгол-Зөвлөлтийн түүх, соёлыг судлах хүрэлэн тухайн газарт ажилласны үр дүнд Түрэгийн язгууртны тахилын онгоны байгууламжуудыг хэлбэр, бүтэц, зохион байгуулалтаар нь ангилж үүрэг зориулалтаар нь тодорхойлсон бөгөөд Монголын төв нутаг дахь чулуун дурсгалуудыг тусгайлан судалсан бүтээлүүд хэвлэгдэн гарсан байна.

1997 оноос Монгол Туркийн хамтарсан **“Монгол нутаг дахь Түрэгийн үеийн зарим хөшөө дурсгалуудыг хадгалж хамгаалах, судлах, сэргээн засварлах нь”** төслийн хүрээнд Хөшөө Цайдамын цогцолбор дурсгалын судалгаанд шинэ хуудас нээсэн томоохон судалгаа хийгджээ. Энэхүү судалгаагаар уг дурсгалын нийт талбайн геодезийн нарийвчилсан зураглал үйлдэж гео-соронзон судалгаа хийн, эвдэрч, элэгдсэн чулуун хөшөөний хэв, сорьц авч шинжлэх судлав.

1998 оноос хэрэгжсэн Монгол-Японы хамтарсан **“Бичээс”** төслийн хээрийн шинжилгээний анги Хөшөө Цайдамын дурсгалын бичигт хөшөөнүүдийг нягтлан судлахын зэрэгцээ дурсгалуудын хоорондын зай, балбал чулуунуудын тоог нарийвчлан гаргаж байрлалын зураг гаргасан байна. 2000 оноос тус төслийн хээрийн шинжилгээний анги Билгэ хааны тахилын болон энд шинээр илэрсэн тахилын жижиг онгоныг малтан судалж 2 шувууны дүрстэй уран нарийн сийлбэр бүхий 4 хавтан чулуу, жижиг алтан цар, халбага зэрэг олдвор илрүүлэн олжээ. Түүнчлэн дурсгалуудын талбайд орших, эвдэрч муудсан хүн чулуу, чулуун хонь, балбал чулуу болон бусад чулуун дурсгалуудыг музейн барилгын дотор оруулан сэргээн засварлах ажлыг дэс дараатай гүйцэтгэж эхэлжээ.

2001 онд Билгэ хааны онгоныг малтан шинжилсэн судалгааны үр дүн.

Тус малтлага судалгааны ажилд Монголын талаас Д.Баяр, Ч.Амартүвшин, А.Энхтөр, Ж.Гэрэлбадрах, Туркийн талаас Х.Бахар, С.Чечен, И.Дурмуш, Р.Кузуолоу, Г.Гөкчек, Г.Карагуз, М.Бозкуртлар нар ажилласан билээ. Энэхүү малтлага судалгаагаар Билгэ хааны тахилын онгоны бүтэц, зохион байгуулалтын талаар мэдэгдсэн зүйл болон илэрч олдсон олдворуудын талаар товч дурдвал:

1. Чулуун хонинууд: Билгэ хааны онгоны үүдэн хэсгээс боржин чулуугаар хийсэн толгойгүй 2 хонь 15 см гүнээс илэрсэн байна. Энэхүү 2 хонийг онгоны үүдэнд шавар хананы дэргэд өөд өөдөөсөө харсан, зүүн тийш ялимгүй хазайсан байдалтай олдсон байна. Урд талд байрлах чулуун хонийг шаргал боржин чулуугаар /91x89x43см/ хийсэн ба хойд талын чулуун хонийг хөх саарал боржин

чулуугаар /96x66x43,5см/ хийжээ. Толгой хүзүү нь хугарч алга болсон ба суурийн зузаан нь 14 см байв.

2. Гэрэлт хөшөөний яст мэлхий хэлбэртэй чулуун суурь: Энэхүү дурсгал нь 234x154x72 см хэмжээтэй бөгөөд нуруун дээр 84x39x30 см хэмжээтэй гэрэлт хөшөө суурилуулах дөрвөлжин хонхортой. Яст мэлхийний хөлийн хумсы дүрслэл, биеийн гадаргууг өнгөлсөн байдал, гэрэлт хөшөө суурилуулах хонхор зэргийг ухаж гаргасан зэргээс үзэхэд ур хийц сайтай хийсэн нь тодорхой харагдана. Энэ хэсэгт 1930 аад онд бичигт хөшөөг хамгаалах зорилгоор барьсан 4x4 метр хэмжээтэй модон барилгын үлдэгдэл суурь илэрсэн.

3. Мэлхий чулуун суурьтай гэрэлт хөшөөний барилга: Энэхүү дурсгалын орчимд их хэмжээний дээврийн ваарны хагархай улаан өнгийн шавартай холилдон гарсан бөгөөд мэлхий чулуун дурсгалд ойртох тусам ваарны хагархай улаан болон саарал өнгийн шаварлаг давхаргатай холилдон зузаан тогтсон нь уг дурсгалын дээр барьсан барилгын дээврийн ваарны шаваас, мөн ханын шохойн шавардлага бололтой.

4. Шинээр олдсон хүн чулуу: Мэлхий чулуу, тахилын сүм хоёрын хооронд хийсэн малтлагын 4-үе буюу 49 см гүнээс илэрсэн. Уг дурсгалыг цагаан өнгийн бүдүүн ширхэгтэй гантиг чулуугаар урласан бөгөөд 47x42x30см хэмжээтэй. Хүн чулуун хөшөөний толгой, баруун гар нь хугарч алга болсон бөгөөд зүүн гарыг цээжин тус газраа ямар нэгэн хавтгай зүйл барьсан, бүс бүсэлж ар ташаанд хутга хавчуулсан байдалтай дүрсэлжээ.

5. Хонины бүтэн яс: Билгэ хааны тахилын онгоны үүдний хэсэгт орших мэлхий чулуу ба баруун талын тахилын чулуу хоёрын дунд хэсгээс 65 см-ийн гүнээс хонины бүтэн яс гарсан байна.

6. Шинээр олдсон тахилын хашлага чулуу: Энэхүү тахилын хашлага чулуу нь өмнө нь газрын хөрснөөс цухуйж байсан байна. Тахилын хойд талын хавтан чулууны зүүн баруун талын булан хугарсан, харин бусад гурван хавтан чулуу дундуураа тэгшхэн цуулсан байжээ. Дөрвөн хавтан чулуун дээр цэцгэн хээг урлажээ. Хашлага чулууны хойд болон зүүн, баруун талын хавтан чулууг цагаан саарал боржингоор, харин урд талын хавтанг хөндлөн ширхэгтэй өөр төрлийн боржин чулуугаар хийсэн байжээ.

7. Үнэт олдворууд: Тахилын дөрвөлжин чулуу болон дээр дурдсан шинээр олдсон хашлага чулуу хоёрын хоорондох талбайгаас 103 см-ийн гүнээс 8 ширхэг цэцгэн хэлбэртэй мөнгөн товруу, төмөр эдлэлийн хугархай зэргийг олж илрүүлсэн. Энэхүү газраас нийт 17 төрлийн 1878 ширхэг мөнгөн эдлэл, 20 төрлийн 78 ширхэг

алтан эдлэл, 6 төрлийн 26 ширхэг эрдэнийн чулуу зэрэг олдворууд олдсон байна. Эдгээр олдворуудын онцлог нь мөнгөн хөөмөл бугын дүрс 2 ширхэг гарсан ба 5-р үеийн малтлагаар шар өнгийн торгомсог эдээр боож амсрыг нь мушгиж зангидалгүй хийсэн алтан эдлэлүүд цогц байдлаар олдсон байна. Үүнд таван талт алтан титэм, жижиг том хэмжээтэй алт мөнгөн гүц 5 ширхэг, эдгээрийн 1 жижиг мөнгөн гүцнээс бүсний алтан олом 2 ширхэг, алтан оломны хэл 2 ширхэг, алтан сэтэрхий цагираг 2 ширхэг, мөнгөн бүсний чимэглэл 1 ширхэг, эрдэнийн чулуун 14 ширхэг гарсан байна.

Билгэ хааны тахилын онгоныг өргөн хэмжээгээр малтан судлах ажлын гүйцэтгэлийн үд дүнд 3 үндсэн хэсгээс бүрдсэн болохыг тогтоосон байна.

1. Яст мэлхий хэлбэрт гантиг чулуун суурийн дээр байрлуулсан Түрэгийн руни болон хятад бичээст хөшөө бүхий үүдэн хэсэг
2. Тахилын сүм бүхий төв хэсэг
3. Тахилын чулуу орчмын хэсэг гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэж байна.

Хөшөө Цайдамд буй эртний Түрэгийн Билгэ хааны тахилын онгон, Культегин жанжны онгонд 2000-2003 онд Монгол-Туркийн хамтарсан судалгааны баг малтлага судалгаа хийсэн бөгөөд 2018 онд Монгол-Казхастаны хамтарсан хээрийн шинжилгээний анги Хөшөө Цайдам дахь Билгэ хааны онгоны зүүн талд орших нэгэн байгууламжид малтлага хийсэн байна.




Билгэ хааны гэрэлт хөшөө



Культегин жанжны гэрэлт хөшөө

2001 онд хийсэн малтлагаа үргэлжлүүлэн зарим хэсгийг бүрэн баримтжуулж дуусгасан байна. Билгэ хааны онгоны зүүн талд ойрхон түүхий тоосгоор үйлдсэн энэ байгууламж бол уг дурсгалын тоосго, дээврийн ваар, шавар чимэглэл гэх мэт барилгын хэрэглэгдэхүүнийг шатаан үйлдэхэд зориулан байгуулсан “мантуу” хэлбэрийн зуух болов уу хэмээн таамаглаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2002 оны 04 сарын 17-ны өдрийн 71 тоот тогтоолоор соёлын үл хөдлөх дурсгал болох Билгэ хаан, Культегиний хөшөөний хамгаалалтын бүсийг 20.8 кв м байхаар тогтоожээ.




Археологийн олдворууд:

Хархорум хотын туурьд явуулсан археологийн малтлагаар илрүүлсэн дараах үнэ цэнт олдворуудыг Дэлхийн өвийн **"Хөшөө Цайдам"** музейн үзүүллэгийн танхимуудад дэлгэн тавьж аялагч жуулчид, олон нийтэд үзүүлж сурталчлан таниулж байна.

Билгэ хааны танилын онгоноос илэрсэн алт, мөнгөн эдлэлүүд



Алтан титэм



Алтан чимэглэл



Алтан ээмэг



Мөнгөн буга



Алтан сав

Ном зүй

1. Д.Баяр. монголын дундад зууны археологийн судалгаа II боть. Улаанбаатар 2013 он
2. Монголын археологи -2018 он Улаанбаатар 2019 он
3. Соёлын өвийн төв, Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал Х дэвтэр, Архангай аймаг Улаанбаатар 2013 он
4. Соёлын өвийн үндэсний төв, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах, Улаанбаатар 2017 он
5. Н.Уртнасан. Түмэн дурсгалт Орхоны хөндий Улаанбаатар 2005 он
6. ШУА, Археологийн хүрээлэн. Монголын археологи-2014. Улаанбаатар 2015он
7. <https://www.tolgoilogch.mn/>